

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд хийсэн шалгалтын товч тайлан

Шалгалтанд нийт 18 үйлчилгээ эрхлэгч хамрагдсанаас тусгай зөвшөөрлийн дагуу радио давтамжийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа нь телевизийн өргөн нэвтрүүлгийн 6, Утасгүй агаарын олон сувгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 1, радио өргөн нэвтрүүлгийн 5, ISP утасгүй интернэт үйлчилгээ үзүүлэгч 0, нийт 12 тусгай зөвшөөрөл эзэмшигчид байсан. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулаагүй байсан болно.

Хөвсгөл аймгийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд нэвтрүүлэгч болон нэвтрүүлэх антенуудаа тус тусын байран дээрээ байрлуулан үйл ажиллагаагаа явуулж байлаа.

Хууль бусаар зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 2 байгууллага болон хувь хүн байсан.

Радио өргөн нэвтрүүлэг

Нийт 7 аж ахуй нэгж, компаниуд байгаагаас үйл ажиллагаагаа явуулж буй 4 тусгай зөвшөөрөл эзэмшигч байлаа. Нэг иргэн тусгай зөвшөөрөлгүйгээр радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулж байлаа.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ нь тусгай зөвшөөрлийн дагуу 98.5МГц-ийн давтамж дээр үйл ажиллагаа хэвийн явагдаж байв.

Хөгжлийн салхи нийгэмлэг ТББ нь тусгай зөвшөөрлийн дагуу 104.5МГц-ийн давтамж дээр үйл ажиллагаа явуулж байсан ба нэвтрүүлэгчийн гаралтын чадал тусгай зөвшөөрөлд зааснаас их байлаа. Радио Телевизийн Сүлжээ УТҮГазар нь тусгай зөвшөөрлийн дагуу 103МГц-ийн давтамж дээр үйл ажиллагаа явуулж байсан ба нэвтрүүлэгчийн гаралтын чадал тусгай зөвшөөрөлд зааснаас бага буюу 50Вт байхаас 6.84Вт хэмжигдэж, чадал багассан. Радио Телевизийн Сүлжээ УТҮГ ФМ-105.5-ын хувьд нэвтрүүлэх станцын гаралтын чадал тусгай зөвшөөрөлд заасан хэмжээнээс бага байсан зэрэг дутагдлууд илэрсэн болно. Ауразон ХХК ФМ89.9, Шинэ Монгол Долгион ХХК ФМ106.3, Скай КаТВ ХХК ФМ107 радионууд нь үйл ажиллагаа явуулаагүй байв.

ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭ

Иргэн Б.Мөнхчулуун нь Мөрөөдлийн мөрөн ФМ101.5 радиог тусгай зөвшөөрөлгүйгээр ажиллуулж байв. Иргэн Б.Мөнхчулуунтай уулзаж “Радио долгионы тухай хууль” болон бусад журмыг танилцуулж зөвлөгөө өгсөн. Тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд радио давтамж ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл болохыг сануулж үйл ажиллагааг нь зогсоосон болно.

Телевизийн өргөн нэвтрүүлэг

Тус суманд 6 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 5 телевиз үйл ажиллагаагаа явуулж байлаа. Эдгээр телевизүүдийн нэвтрүүлэх станц болон, ашиглаж байгаа радио давтамжийн зурваст хэмжилт хийхэд дараах зөрчил дутагдлууд илэрлээ.

- Нэвтрүүлэх станцын гаралтын чадал тусгай зөвшөөрөлд заасан хэмжээнд хүрэхгүй бага байх эсвэл заасан хэмжээнээс их байх
- Ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн марк үзүүлэлтийг өөрчилсөн тухайгаа мэдэгдэж тусгай зөвшөөрөлд тусгуулаагүй.

Мөрөн суманд телевизийн 12-р суваг дээр телевиз зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж байлаа. Шалгахад тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан иргэн Л.Цэрэнжавын Чандмань телевиз болох нь тогтоогдлоо. Тухайн телевизийг хариуцан ажиллуулж байгаа Бэхчулуун болон бусад ажилчдад нь тусгай зөвшөөрөлгүйгээр телевизийн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа явуулж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл болохыг хэлж үйл ажиллагаагаа зогсоохыг сануулсан.

Телевизийн олон сувгийг дамжуулах MMDS үйлчилгээ

Нийт 4 телевизийн олон сувгийг дамжуулах MMDS-ийн тусгай зөвшөөрөл эзэмшигч байдгаас Лха хөх тэнгэр ХХК үйлчилгээгээ явуулж байлаа. Радио давтамжийн зурвас ашиглалт хэвийн байлаа.

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдэд хийсэн хэмжилт

Үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнител групп ХХК, Скайтел ХХК, Жи-Мобайл ХХК оператор компаниудын тусгай зөвшөөрлийн радио давтамжуудад гадны харилцан нөлөөлөл илрээгүй бөгөөд давтамж ашиглалт хэвийн байв.